



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/18

Бор-өндөр сум

Төлбөртэй тусламж үйлчилгээний журам,
жагсаалт, үнийн тарифыг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай хамтарсан 49/а118 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэгдсэн эмнэлгийн “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, үнийн тариф”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалтай иргэдэд өвчний учир шалтгаанаар болон эмчийн заалтаар зайлшгүй хийгдэх тусламж үйлчилгээг төлбөр чирэгдэлгүй, түргэн шуурхай, чанартай үзүүлэхийг нийт эмч, ажилчдад үүрэг болгосугай.

3. Төлбөрийг байгууллагын төрийн сангийн 100182720001 тоот дансанд төвлөрүүлж сар, улирал, жил тутам тайлан гаргахыг нярав (Э.Оюунболор)-т, орлогын тодорхой хувийг эмч, ажилчдын ажлын байрны нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дарга (Б.Энхмаа)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР



Нэгдсэн эмнэлгийн даргын
2023 оны 11-р сарын 13 өдрийн А/Х тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдйн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР.ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОЛСОН ОРЛОГЫН БҮРТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТ

2.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу захиран зарцуулна.

2.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой зардалд зарцуулна.

2.3 Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлөх бүхий л төрлийн боломжоор хангаж төлбөрийг төрийн сангийн 100182720001 тоот дансанд төвлөрүүлнэ.

2.4 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн прагмомид бүртгэж, тайлагнаж ажиллана.

2.5 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийг төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, хувь хүний төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

ГУРАВ.ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ХОРИГЛОХ ЗҮЙЛ

3.1 Эмч, эмнэлгийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

3.1.1 Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх.

3.1.2 Ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх.

3.1.3 Үйлчлүүлэгчээс байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах.



ДӨРӨВ.ХЯНАЛТ

4.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг удирдлагын баг хүлээнэ.

4.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд Дотоод хяналтын баг хяналт, шинжилгээ, үнэлгээ дүгнэлт хийж, зөвлөмж гаргана.

4.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийг нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллана.


ТАВ.ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

5.2 Иргэн нэмэлт үйлчилгээтэй холбоотой асуудлаар байгууллагад гомдол гаргах эрхтэй.

5.3 Эрх бүхий тушаалт нь энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

5.4 Энэ журмын 5.3-т зааснаар иргэний төлбөрийг барагдуулсан бол Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.



Нэгдсэн эмнэлгийн даргын
2023 оны 11-р сарын 13 өдрийн 1/3 тоот
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

Төлбөртэй тусламж үйлчилгээ

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Төлбөрийн жишиг хэмжээ
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ		
1	АЛАТ	3,000
2	Альбумин	3,000
3	Амилаза	5,000
4	Антистрепитолизин O тест (ASLO/ASO) (тоогоор)	10,000
5	АСАТ	3,000
6	Билирубин нийт	3,000
7	Билирубин шууд	3,000
8	Билирубин шууд бус	3,000
9	ГГТ Гаммаглутамилтрансфераза	3,000
10	Глюкоз	3,000
11	Кали	5,000
12	Кальци	4,000
13	Креатинин	4,000
14	ЛДГ	4,000
15	Лапиза	6,000
16	Магни	4,000
17	Мочевин	4,000
18	Натри	5,000
19	Нийт уураг	3,000
20	Нийт уураг (Шээс)	6000
21	Нойр булчирхайн амилаза (П амилаза)	6,000
22	Ревматоид фактор /RF/(Тоогоор)	9,000
23	Сурвалжийн уураг (CRP)(тоогоор)	11,000
24	Төмөр	4000
25	Триглицерид	3,000
26	Фосфор	3,000



27	Хлор	5,000
28	Холестерин	3,000
29	Шүлтлэг фосфотаза	4000
30	Шээсний осмос тодорхойлох	5,000
31	Шээсний хүчил (цус)	3,000
32	Шээсний хүчил (шээс)	3,000
33	Шээсэнд глюкоз тодорхойлох	5,000
34	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	14,000
35	Резусийн фенотил/ССЕе/тохирсон хувийн тохироотой улаан эс	180,000
36	Резусын дэд бүлэг тодорхойлох	20,000
37	Цусны бүлэг, резус	11,000
38	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор) баталгаажуулах	6,000
39	Цусны хувийн тохиргоо тодорхойлох	15,000
40	Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил (TRHA)	5000
41	Шимэгч хорхойн өндөг илрүүлэх /натиз харах/	5,000
42	УЭ-Бүхэл цус	102,000

АМБУЛАТОРИОР ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1	Эмчийн үзлэг	20,000
2	Хэт авиа (зүрх бамбай булчирхай, хөх, Захын судас нярайн зулай, цээж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхтэн, гүрээний артер, зөөлөн эд, шөрмөс үе тархины судасны доплер, тархины судасны дүплекс)	15,000
3	Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал хамар, цээж, хүзүү, ууц нуруу, ахар сүүл сээр, дээд мөч, доод төч, аарцаг аденойз, дал, өвчүү, ухархай хавирга, чих эгэм, эрүү)	10,000
4	Зүрхний цахилгаан бичлэг	9,000
5	Ургийн зүрхний цахилгаан бичлэг	30,000
6	Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000
7	Рентгений хяналтанд хийх ажилбар	60,000



8	Арьсны хоргүй хавдар, үү, ургацыг авах, /байрлал хэмжээнээс хамаарч олон тооны жижиг хэмжээтэй бол/	80,000
9	Сэтэрхий чих оёх /2 тал/	45,000
10	Хамар, чих, нүднээс гадны биет авах	20,000
11	Мэс ажилбар (идээ, буглаа нээх г.м)	27,000
12	Боолт	10,000

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ

1	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илүүлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Багцаас хамааран гэрээний дүнгээр
2	Буу галт зэвсэг эзэмших, сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах	20,000
3	Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд харагдах	80,000
4	Гэр бүл болох ажил, сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдах	80,000
5	Жолооны үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах	50,000
6	Багш нар болон үйлчилгээний байгууллагын урьдчилан сэргийлэх багц үзлэг	40,000

ГЭРЭЭР СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1	Боолт хийх	20,000
2	Дуслаар тариа хийх	20,000
3	Судсанд тариа хийх	15,000
4	Булчинд тариа хийх	15,000
5	Арьсан дор тариа хийх	15,000
6	Ходоод угаах	25,000
7	Судсанд гуурс тавих	20,000
8	Давсаг угаах	25,000
9	Шээс авах	25,000

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ



1	Бикс, боодол ариутгал (том, жижиг, дунд)	15,000
2	Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл /м2/	450
3	ЭМБ-ын тусгай хог хаягдал цуглуулах устгах (кг)	20,000
4	Захиалгат хоол	5,000-15,000
5	Архивын лавлагаа	3,000
6	Албан бланк дээр эмнэлгийн тодорхойлолт гаргах	3,000
7	Үйлчилгээний талбайн түрээс	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 тоот тогтоолыг үндэслэн хэлэлцээр, гэрээгээр
8	Эмнэлгийн машинаар өвчтөн тээвэрлэх (км)	2,000
9	Эмнэлгийн машинаар, мэргэжлийн эмч, сувилагчтай өвчтөн тээвэрлэх	Тухайн үеийн бодит зардлаар
ГАДААДЫН ИРГЭНИЙ ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО		
1	Эмчийн үзлэг	40.000
2	Гадаадын иргэний урьдчилан сэргийлэх үзлэг (4 халдвар, сүрьеэ, эмчийн үзлэг)	150.000
3	Бусад тусламж үйлчилгээ	Тухайн үеийн бодит зардлаар
ЦОГЦОЛ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Шарил хадгалах үйлчилгээ (нэг хоногт эмнэлэгийн нас баралтаас бусад тохиолдолд)	28,000
2	Шарил тээвэрлэх үйлчилгээ (1 км-т)	3,000